

2020 ОНЫ ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУЛЬД БИЕ  
ДААН НЭР ДЭВШИГЧ БАЛЖИННЯМЫН БУЛГАНЧИМЭГИЙН МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР

**Нэг. Орчин**

- Эко хот эко баг

**Хоёр: Ажлын байр**

- Үйлдвэрлэгч - Хэрэглэгч

**Гурав. Хүнд суртал**

- Төрийн үйлчилгээ – Иргэн төвтэй

**Дөрөв. Ил тод байдал**

- Шилэн данс - Авилгалгүй хот



*Б.Боржигжимж*

**ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
БАЛЖИНЯМ ОВОГТОЙ БУЛГАНЧИМЭГИЙН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Сонгуулийн уриа: Хотын иргэд хотоо хөгжүүлнэ.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан. Аймгийн ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд “Эрдэнэт” хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх зорилтот ажлууд, тухайн нэр дэвшигчийн нэр дэвших баг дээр хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх зорилтуудыг 2 хэсэгт багтаан томъёолж өгсөн болно.

**Зорилт 1.”Эрдэнэт” хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд**

- 1.1. Эрдэнэт хотын хамтын ажиллагаатай гадаадын хотын туршлагатай танилцан хотын хөгжил, ногоон байгууламжийн шинэлэг санааг өөрийн хотод дэлгэрүүлэн, анхан шатны байгуулагыг гадаад харилцаатай болоход нь дэмжин ажиллана.
- 1.2. Уул уурхайн салбараас орох орлогыг одоо болон ирээдүй хойч үедээ тэгш хүртдэг оновчтой хувиарлуулах тал дээр Эрдэнэт хотоос УИХ-д сонгогдсон гишүүдтэй хамтран ажиллаж, эрх зүйн орчинг нь бүрдүүлнэ.
- 1.3. Хөдөлмөрийн чадвартай иргэдийг ажлын байраар хангах, хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийг дэмжин ажлын байр бий болгох тал дээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4. Ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг олноор бий болгохтой холбогдуулан ЖДУ сан болон бусад дэмжлэгийн сангүүдүүн үйл ажиллагааг ил тод хүртээмжтэй байхад анхаарч дэмжиж ажиллана.
- 1.5. Эрдэнэт хотын захиргаа, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд байгаль орчны бохирдол хүн, амьтны эрүүл мэндэд сэргээр нөлөөлж буй асуудлууд, гол ус, хөрсний бохирдол, цагаан тоосныг арилгах, ундны усны хамгаалалт, тал дээр онцгой анхаарч ажиллана.
- 1.6. Хотын хүн ам өсөн нэмэгдэж буйтай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн хангалт хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр үе шаттай бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.7. Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Медипас зэрэг иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй эмнэлэгүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах, зайлшгүй техник, тоног төхөөрөмжөөр хангах, эмч эмнэлэгийн ажилтнуудыг давтан сургах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэд саадгүй түргэн шуурхай авч байх тал дээр анхаарч ажиллана.
- 1.8. Иргэдэд анхан шатны эмнэлэгийн тусlamж үзүүлдэг **Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байр, техник, тоног төхөөрөмжтэй болоход онцгой анхаарч үе шаттай шийдвэрлэнэ.**
- 1.9. Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих хүрээнд үйл ажиллагаа явтуулж буй клубууд, спортын холбоодын зохион байгуулалтыг бодлогоор дэмжин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортыг хөгжүүлэх, дэмжин туслах тал дээр дэмжин ажиллана.
- 1.10. Ахмад, Эмэгтэйчүүд, Залуучууд, хүүхдүүд рүү хандсан нийгмийн харилцааг зохицуулах, дэмжсэн дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлнэ. **Өндөр настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх тал дээр онцгойлон анхаарч ажиллана.**

*Б. Булганчимэг*

1.11. Орхон аймаг нь “Эрдэнэт” хот болж байгаатай уялдуулан хотын соёлыг түгээх, хотын иргэн байх аливаа уриалгыг нийгэмд түгээж ажиллах, сайн санал, санаачлагыг дэмжиж хамтран ажиллана.

1.12. Энэхүү мөрийн хөтөлбөр нь УИХ-аас баталсан хөгжлийн үзэл баримтлал болох Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нягт уялдан хэрэгжих юм.

#### Зорилт 2. Багийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

2.1. Ахмад настанд зориулсан сургалт явуулж, ахмад мэргэжилтэнийг дэмжих, эцэг эхчүүд гэр бүлд зориулсан нийтийг хамарсан үйл ажиллагааг тогтмол явуулж, хүүхэд, залуусын нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх төвийг байгуулах зэрэг иргэдийн аливаа санаачлагыг дэмжиж ажиллана

2.2. Багийн харьяалал бүхий ажил хөдөлмөр идэвхитэй хайж байгаа иргэдэд туслах зорилго бүхий Хөдөлмөрийн бирж ажиллуулах бодлого зохицуулалт хийж, уулзалт сургалт зохион байгуулан хорооны нийгмийн ажилтан, хөдөлмөр халамжийн мэргэжилтэнтэй хамтран ажиллана.

2.3. Багийн нутаг дэвсгэрт буй ногоон байгууламжийн төрлийг нэмэгдүүлэх зорилгоор модны суулгац, цэцгийн мандал тарьж ургуулдаг багийн иргэдийг дэмжин хотын хэмжээнд өнгө нэмэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг нээж өгнөб

#### ЗОРИЛТ 3

3.1 Иргэдийн эрх зүйн болон улс төрийн мэдлэг, соёлыг дээшлүүлж, хариуцлагатай иргэн болгоход дэмжлэг үзүүлнэ.

3.2 Төрийн үйляилгээг шат дамжлагагүй, шуурхай хүргэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлийг дэмжиж ажиллана.

3.3. Иргэд төрийн байгууллагын албан тушаалтнуудтай цахим хэлбэрээр харилцах соёлыг хэвшүүлэхэд анхаарч ажиллана.

3.4 Төрийн байгууллагын үйлчилгээнд хүнд суртал, авлига хамгийн их үүсгэж буй үйлчилгээг цахимжуулах ажлыг дэмжиж ажиллана. цахим гааль, цахим татвар, цахим иргэний бүртгэл, цахим шүүх, цахим газрын харилцаа, цахим эрүүл мэнд, цахим боловсрол гэх мэт)

#### ЗОРИЛТ 4

4.1 Улсын болон орон нутгийн төсвийн хувиарлалт, зарцуулалт зохицуулалтын удирдлагыг сайжруулахад иргэдийн оролцоотой хяналт тавихад дэмжлэг үзүүлж ажиллана.

4.2 Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд санадаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох боломжийг бүрдүүлнэ.

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан.....Б.Булганчимэг

*Б.Булганчимэг*

611743690  
РААДУУЗ 0042806

2020.07.31